



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Булган сумын ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2025/58/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Архангай аймаг
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ

Утас: 99210906

Цахим хаяг: Tsogerdeneg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.02.20 № 28
танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Э.БАДАМ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Булган сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Булган сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд орон нутгийн ээлжит сонгууль болж Булган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч шинээр сонгогдсон байна. Төлөөлөгчдийн 15,750.0 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 74.6 хувь буюу 11,750.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 4,000.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээний хүрээнд орон нутгийн төсвөөс **195,682.9** мянган төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэл 97.9 хувь буюу **191,594.4** мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 4,088.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 үндсэн зорилтын хүрээнд 37 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг сумын ИТХ-ын даргаас 98 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,418,900.00</u>	<u>6,227,400.00</u>
БАРАА МАТЕРИАЛ	5,418,900.00	6,227,400.00
Хангамжийн материал	5,418,900.00	6,227,400.00
Аж ахуйн материал	5,418,900.00	6,227,400.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>6,894,613.80</u>	<u>5,436,009.64</u>
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,894,613.80	5,436,009.64
Биет хөрөнгө	6,894,613.80	5,436,009.64
Машин тоног төхөөрөмж (компьютер)	12,433,820.00	13,073,820.00
Хуримтлагдсан элэгдэл	(5,701,706.20)	(7,722,310.36)
Тавилга, аж ахуйн эд хогшил	993,040.00	993,040.00
Хуримтлагдсан элэгдэл	(830,540.00)	(908,540.00)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>12,313,513.80</u>	<u>11,663,409.64</u>
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>12,313,513.80</u>	<u>11,663,409.64</u>
Засгийн газрын хувь оролцоо	12,313,513.80	11,663,409.64
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,052,000.00	2,052,000.00
Өмч: - төрийн	2,052,000.00	2,052,000.00
Хуримтлагдсан үр дүн	10,253,689.80	9,603,585.64
Өмнөх үеийн үр дүн	10,253,689.80	10,253,689.80
Тайлант үеийн үр дүн	-	(650,104.16)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,824.00	7,824.00
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>12,313,513.80</u>	<u>11,663,409.64</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	106,321,600.00	195,682,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	106,321,600.00	195,682,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	106,321,600.00	195,682,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	106,321,600.00	195,682,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	105,759,204.12	196,333,004.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	105,759,204.12	196,333,004.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	103,183,195.69	164,401,004.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	78,605,591.57	130,780,000.00
210101	Үндсэн цалин	51,816,378.15	87,565,142.96
210102	Нэмэгдэл	16,981,437.79	37,634,792.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,735,466.50	5,580,064.50
210104	Урамшуулал	5,072,309.13	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,147,700.00	16,347,500.00
210201	Тэтгэврийн даатгал	6,900,400.00	11,116,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	811,800.00	1,307,800.00

Архангай аймгийн Булган сумын ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210203	ҮОМШӨ-ний даатгал	649,500.00	1,046,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	162,400.00	261,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,623,600.00	2,615,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,007,300.00	9,123,400.00
210401	Бичиг хэрэг	1,678,000.00	2,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,000,000.00	5,000,000.00
210404	Ном, хэвлэл	122,000.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,207,300.00	2,023,400.00
2107	Томилолт, зочны зардал	1,500,000.00	1,500,000.00
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,000,000.00	2,360,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,000,000.00	2,360,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,922,604.12	4,290,104.16
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,191,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,922,604.12	2,098,604.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,576,008.43	31,932,000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	11,750,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	11,750,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	16,093,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	16,093,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,576,008.43	4,088,500.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,576,008.43	4,088,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>562,395.88</u>	<u>(650,104.16)</u>
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>562,395.88</u>	<u>(650,104.16)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>106,321,600.00</u>	<u>195,682,900.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>106,321,600.00</u>	<u>195,682,900.00</u>
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	106,321,600.00	195,682,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	106,321,600.00	195,682,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>106,321,600.00</u>	<u>195,042,900.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>106,321,600.00</u>	<u>195,042,900.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>103,745,591.57</u>	<u>163,110,900.00</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	78,605,591.57	130,780,000.00
210101	Үндсэн цалин	51,816,378.15	87,565,142.96
210102	Нэмэгдэл	16,981,437.79	37,634,792.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,735,466.50	5,580,064.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,147,700.00	16,347,500.00
210201	Тэтгэврийн даатгал	6,900,400.00	11,116,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	811,800.00	1,307,800.00

210203	ҮОМШӨ-ний даатгал	649,500.00	1,046,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	162,400.00	261,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,623,600.00	2,615,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,492,300.00	9,123,400.00
210401	Бичиг хэрэг	1,678,000.00	2,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,000,000.00	5,000,000.00
210404	Ном, хэвлэл	122,000.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,692,300.00	2,023,400.00
2107	Томилолт, зочны зардал	1,500,000.00	1,500,000.00
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,000,000.00	2,360,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,000,000.00	2,360,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	3,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,576,008.43	31,932,000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	11,750,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	11,750,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	16,093,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	16,093,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,576,008.43	4,088,500.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,576,008.43	4,088,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	640,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	640,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	640,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	640,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	640,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	(640,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	2,052,000.00	7,824.00	10,253,689.80	12,313,513.80
C07	Тайлант үеийн үр дүн		0.00	(1,573,953.12)	(1,573,953.12)
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,052,000.00	7,824.00	10,253,689.80	12,313,513.80
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл				-

D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайлант үеийн үр дүн		0.00	(650,104.16)	(650,104.16)
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,052,000.00	7,824.00	9,603,585.64	11,663,409.64

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	195,682,900.0	191,594,400.0	4,088,500.0	97.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	195,682,900.0	191,594,400.0	4,088,500.0	97.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	163,750,900.0	163,750,900.0	-	100.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	130,780,000.0	130,780,000.0	-	100.00
210101	Үндсэн цалин	130,780,000.0	87,565,143.0	43,214,857.0	66.96
210102	Нэмэгдэл	-	37,634,792.5	(37,634,792.5)	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	5,580,064.5	(5,580,064.5)	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,347,500.0	16,347,500.0	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	11,116,300.0	11,116,300.0	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,307,800.0	1,307,800.0	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,046,200.0	1,046,200.0	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	261,600.0	261,600.0	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,615,600.0	2,615,600.0	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,123,400.0	9,123,400.0	-	100.00
210401	Бичиг хэрэг	2,000,000.0	2,000,000.0	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	5,000,000.0	5,000,000.0	-	100.00
210404	Ном, хэвлэл	100,000.0	100,000.0	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,023,400.0	2,023,400.0	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	1,500,000.0	1,500,000.0	-	100.00
210702	Дотоод албан томилолт	1,500,000.0	1,500,000.0	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,000,000.0	3,000,000.0	-	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,000,000.0	3,000,000.0	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.0	3,000,000.0	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.0	3,000,000.0	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,932,000.0	27,843,500.0	4,088,500.0	87.20
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	15,750,000.0	11,750,000.0	4,000,000.0	74.60
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	15,750,000.0	11,750,000.0	4,000,000.0	74.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,182,000.0	16,093,500.0	88,500.0	99.45

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,182,000.0	16,093,500.0	88,500.0	99.45
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	195,682,900.0	191,594,400.0	4,088,500.0	97.91
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	195,682,900.0	191,594,400.0	4,088,500.0	97.91
132001	Орон нутгийн төсвөөс	195,682,900.0	191,594,400.0	4,088,500.0	97.91
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-	0.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-	0.00	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	3.00	3.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	2.00	2.00	0.00	100.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 1,448.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулав.

Залруулсан алдаа:

- 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Бараа материалын бусад хөрөнгөд 808.5 мянган төгрөгийн танилцуулга самбар, үндсэн хөрөнгөд 640.0 мянган төгрөгийн камерыг бүртгээгүй байсныг аудитын явцад тусгуулан залруулга хийлгэв.

Аудитаар нийт 4,256.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 1,926.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 2,330.8 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлсэн.

Аудитаар залруулагдаагүй 3 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 1,926.0 мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн **2,201.4** мянган төгрөгөөс бага, шинж чанарын хувьд материаллаг бус байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

3.1 Зөвлөмж

3.1.1. Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 1 нэр төрлийн 3 ширхэг 2,330.8 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж байгаа бөгөөд хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заасныг хэрэгжүүлж холбогдох арга хэмжээг авч ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 03 дугаарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Зөвлөмжийн биелэлтийг тооцож, нотлох баримтыг хангуулан 2025 оны 06 дугаар сарын 20-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

3.2 Төлбөрийн акт

3.2.1. Булган сумын ИТХ-ын даргын 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 02 дугаар захирамжаар ИТХ-ын нарийн бичгийн дарга Э.Бадамд 9,582.0 мянга, Булган сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн Б/04 дүгээр тушаалаар сумын ИТХ-ын ажлын албаны мэргэжилтэн Ж.Одгэрэлд 6,511.5 мянга нийт 16,093.5 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан үндэслэлээр тус тус олгосон бөгөөд урамшууллаас хувь хүний орлогын албан татвар 10 хувь болох 1,609.3 мянган төгрөгийг суутгаж төсөвт шилжүүлээгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-т "Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 7 дугаар зүйлийн 7.1-д "Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна, 7.1.1-д "Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого" , 21 дүгээр зүйлийн 21.1-д "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар ... албан татвар ногдуулна" гэсэн заалтуудтай нийцэхгүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аймгийн төсвийн орлогын 1001000955 данс руу суутган төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

3.2.2. Сумын ИТХ-ын мэргэжилтний албан тушаалыг хавсран гүйцэтгэсэн сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Э.Бадамд сул албан тушаалын үндсэн цалингаас бус нарийн бичгийн даргын албан тушаалын үндсэн цалингаас тооцож 316.7 мянган төгрөгийг илүү олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, МУЗГ-ын 2019 оны 9 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын 2.2 дахь заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аймгийн төсвийн орлогын 1001000955 данс руу буцаан төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Бараа материал, үндсэн хөрөнгийг дутуу бүртгэсэн	1	1,448.5	1	1,448.5			1	1,448.5				
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй	1	2,330.8					1	2,330.8				
16,093.5 мянган төгрөгийн тогтвор суурьшилтай ажилласны 6 сарын үндсэн цалинтай	1	1,609.3	1	1,609.3								

Архангай аймгийн Булган сумын ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

тэнцэх хэмжээний тэтгэмжийг тооцож олгохдоо хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй.											
албан тушаалыг хавсран гүйцэтгэсэн нэмэгдлийг илүү тооцож олгосон	1	316.7	1	316.7							
Дүн	3	4,256.8	2	2,330.8			1	2,330.8			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Булган сумын ИТХ						-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Булган сумын ИТХ	0	0	0	0	0	0	0	0